

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн,
үр нөлөө

АУДИТЫН КОД: БУА-2024/26-03-ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ
2024 ОН

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ОНХС-аас сумын аймаг, сумдын ОНХС-д олгосон шилжүүлэг	
Хүснэгт 2	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт	
Хүснэгт 3	Аймаг, суманд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой зөрчил	
Хүснэгт 4	ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаа	
Хүснэгт 5	ИТХ-аар баталсан хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт	

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоон үзүүлэлтэд	
Дүрслэл 2	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ангилал	

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн хуваарь, санхүүжилтийн гүйцэтгэл	
Хавсралт 2	ОНХС-гийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийн зөрчлийн шийдвэрлэлт	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/152 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр Онөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ▪ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын баримт материал болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, багийн ИНХ, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын холбогдох үйл ажиллагааг хамруулаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт <i>MNS 6817-3:2020 “Төрийн аудит. Чанарын хяналт”</i>, <i>MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”</i>, <i>MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”</i>, <i>MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”</i>-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд

**Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”,
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Д.Анхбаяр, П.Содном, аудитор Д.Даариймаа, З.Ганбаатар нар 2024 оны 05 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

**Ерөнхий
мэдээлэл:**

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар, 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталжээ.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд зааснаар ОНХНС болон улсын төсвөөс Булган аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 9,369.0 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХСангийн харилцах дансны эхний үлдэгдэл 2,633.4 сая төгрөг, ОНХНС болон Улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгээс 8,796.5 сая төгрөг, "Тогтвортой амжиргаа-3" төслийн урамшууллаас 255.1, Орон нутаг ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэрээс 1,118.4 сая төгрөг, Малын хөлийн тоо толгойн албан татвараас 1,320.5 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 436.8 сая төгрөг нийт 11,858.2 сая төгрөг Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн 10,942.5 сая төгрөг ОНХС-гийн харилцах дансанд 3,618.1 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд ИТХ-аар 15,472.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 465 төсөл, арга хэмжээг баталж үүнээс гэрээ байгуулан ажилласан 12,202.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 363 төсөл арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 8,461.8 сая төгрөгийн 333 төсөл, арга хэмжээ, 3,728.4 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээг дутуу, 2,893.7 сая төгрөгийн 101 төсөл арга хэмжээг огт хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

БҮЛЭГ 1

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэрийг бүрэн төлөвлөөгүй, ОНХС-аас олгох шилжүүлгийг бүрэн хуваарилсан байна.

1.1.3. Аймгийн ОНХС-аас болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг сумдад 35.1 сая төгрөгийг дутуу олгосон, батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд Булган аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 9,369.0 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2 дахь заалтын дагуу 4,812.04 сая төгрөгийг сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан аймгийн Засаг даргын 2023 оны А/667 дугаар захирамжаар аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг батлан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт № 1 Аймгийн ОНХС-аас сумын аймаг, сумдын ОНХС-д олгосон шилжүүлэг (сая.төг)

№	Сум	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалт ын дүн	ТА-3 төслийн урамшуул ал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалты н тусгай зөвшөөрлий н төлбөр	Нийт суманд хуваарил агдсан дүн
1	Баян-Агт	277.65	-	-	-	277.65
2	Баяннуур	145.37	20.19	1.70	1.36	168.63
3	Бугат	164.25	-	-	0.76	165.01
4	Булган	359.32	-	-	-	359.32
5	Бүрээхангай	221.80	-	23.58	64.78	310.15
6	Гурванбулаг	256.02	35.00	-	0.66	291.69
7	Дашинчилэн	239.14	33.08	-	33.57	305.79
8	Могод	220.68	-	0.03	-	220.70
9	Орхон	221.21	-	-	81.45	302.66
10	Рашаант	258.79	-	5.71	-	264.50
11	Сайхан	246.46	-	-	2.42	248.88
12	Сэлэнгэ	312.00	-	-	11.54	323.53
13	Тэшиг	486.26	67.92	-	12.06	566.23
14	Хангал	274.49	39.21	-	-	313.70
15	Хишиг-Өндөр	192.36	-	5.97	0.05	198.38
16	Хутаг-Өндөр	435.51	59.70	-	-	495.20
	НИЙТ ДҮН	4,311.29	255.11	36.99	208.65	4,812.04

Аймгийн ОНХС-аас олгох санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу шилжүүлгийг 2, 9 саруудад 763.3 сая төгрөгийн санхүүжилтийг огт олгоогүй, 7, 8,10, 11, 12 дугаар саруудад нөхөж шилжүүлсэн нь ОНХС-ийн орлогын эх үүсвэр Сангийн яаманд хоцорч төвлөрсөнтэй холбоотойгоор сумдын ОНХС-ийн хөрөнгийг

хуваарийн дагуу шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.4, 41.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчихөд хүргэсэн байна. (Хавсралт-1)

1.1.4. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад 3,593.3 сая төгрөгийн илүү төлөвлөсөн байна.

Аймаг, сум нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2¹ болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т заасны дагуу аймаг, сумд нь ОНХС-ийн эх үүсвэрийг 5 төрлийн орлогоор төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад 3,593.3 сая төгрөгийн илүү төлөвлөсөн дэвшил гарсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт (сая.төг)

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	1,831.59	18.27
ОНХС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	4,556.89	45.44
Тогтвортой амьжиргаа -3 төсөл урамшуулал	255.11	2.54
Малын тоо толгойн албан татвар	1,739.09	17.34
ТТХ-ийн 60.2.4 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	1,116.16	11.13
Бусад орлого	528.89	5.27
Нийт дүн	10,027.7	100.00

ОНХС-гийн эх үүсвэрийг хууль, журамд заасан зарим нэр төрөл болон бусад эх үүсвэрээр нэмэгдүүлсэн байна.Тухайлбал:

- Орон нутгийн давсан орлогоос Булган сум 23.3, Рашаант сум 139.2, Тэшиг сум 111.9, Хангал сум 693.5,
- Бүрэгхангай сум уул уурхайн аж ахуй нэгжүүдийн нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хандив 500.0, Гурванбулаг сум иргэдээс өгсөн хандив 9.8,
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх буюу малын хөлийн татварын орлогоос 16 сум 1 тосгон 1,739.1,
- Аймгийн ОНХС болон Булган сум нь ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдлийг ИТХ-аар батлуулаагүй байна. (Судалгааны хүснэгт-1)

Тогтвортой амьжиргаа-3 төслийн урамшуулал авах нөхцөл хангасан Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр зэрэг сумд 19.6-67.9 сая төгрөгийн урамшуулал авч эх үүсвэрийг нэмэгдүүлсэн сайн жишээ байна.

Харин бусад сумдын хувьд урамшууллаар ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

Иймд ОНХС-ийн эх үүсвэрийг орлогын эх үүсвэр тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэхэд сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нар идэвх санаачилгатай ажиллаагүй байна.


¹ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журам зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.2, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Аймаг, сумын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 19,328 өрхөөс сонгууль өгөх насны 39,829 иргэдээс 22,861 иргэн буюу 57.3 хувь нь хамрагдан санал өгсөн байна.

График №1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоон үзүүлэлтэд эзлэх хувийн жин.



Дээрхээс үзэхэд аймаг сумын хэмжээнд нийт 22,861 санал өгснөөс 1,413 саналыг цахим хэлбэрээр авсан нь нийт саналын 6 хувийг эзэлж байна.

Үүнээс дүгнэхэд аймаг, сумд цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр иргэдээс санал авах ажлыг ОНХС-ийн журмын 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтад заасан хугацаанд хүртээмжтэй байдлаар алслагдсан багийн иргэдийг хамруулж ажиллахад анхаарч ажиллах.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын түвшинд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан ОНХС-ийн хөрөнгөөр 465 төсөл, арга хэмжээг ИТХ-аар 100 хувь нийцүүлэн баталсан сайн жишээ байна.

Харин дээрх 465 төсөл, арга хэмжээнд урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тодорхойлоогүй зөрчил илэрлээ.

1.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх ажлыг хийж хэвшсэн боловч хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журмын шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт № 3 Аймаг, суманд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой

зөрчлийн дүн

(сая.төг)

Д/ д	Аймаг,сумдын нэрс	Батлагдсан төсөл, арга хэмжээ		Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ		ТЭЗҮ, зураг, төсөвгүй		Нийт дүн	
				Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил					
		тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг
1.0	Булган	12.0	407.4			1	35.0	1	35.0
2.0	Орхон	25.0	813.7	6	34.5			6	34.5
3.0	Сэлэнгэ	48.0	420.4	30	193.5	48	420.4	78	613.9
4.0	Хутаг-Өндөр	28.0	801.9	5	52.1	10	120.7	15	172.8
	Нийт дүн	113.0	2443.4	41.0	280.1	59.0	576.1	100.0	856.2

Дээрхээс үзэхэд зөрчил гаргасан сумд нийт ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 16.8 хувь буюу 856.2 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

1.2.4. Аймаг, сумдын түвшинд ОНХС-гийн хөрөнгөөр 14,562.8 сая төгрөгийн 437 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн чиг үүрэгт бүрэн нийцүүлэн төлөвлөсөн байна.

Чиг үүргийг салбараар нь авч үзвэл:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи чиглэлд 65 төсөл, арга хэмжээний 1,054.6 сая төгрөг,
- Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 88 төсөл, арга хэмжээний 1,983.6 сая төгрөг,
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 48 төсөл, арга хэмжээний 1,049.9 сая төгрөг,
- Бэлчээрийн менежментийг сайжруулах 13 төсөл, арга хэмжээний 136.4 сая төгрөг,
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 36 төсөл, арга хэмжээний 352.9 сая төгрөг,
- Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа 18 төсөл, арга хэмжээний 119.2 сая төгрөг.

БҮЛЭГ 2

Аймаг, сум дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллаагүй байна.

2.1.1 Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 14,562.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 437 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл 78.3 хувьтай бөгөөд 2,284.3 сая төгрөгийн 87 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Нийт 11,746.3 сая төгрөгийн 354 төсөл арга хэмжээнд худалдан авах арга хэмжээг зохион байгуулсан байна.

Хүснэгт № 4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаа

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сум	Тайлант жилд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ТАХ-ний		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах		Олон нийтийн оролцоотой худалдан авалт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг ОНХС	11	3769.5	8	3,538.0	3	231.5				
2	Сумдын ОНХС	343	7904.8	9	1,608.3	46	2,281.2	278	3,453.0	10	212.5
	Нийт	354	11674.3	17	5,146.3	49	2,512.7	278	3,453.0	10	212.5

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 343 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний 2.6 хувь буюу 9 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 13.4 хувь буюу 46 ажлыг тендер шалгаруулалтын харьцуулалтын журмаар, 3 хувь буюу 10 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар, 81 хувь буюу 269 ажлыг шууд худалдан авчээ.

Сумдын түвшинд төсөл арга хэмжээний тендерийг зохион байгуулахдаа ТБОНӨХБАУХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- "Хөрсний элэгдэл засварлах, ногоон бүсийн хог хаягдлыг цэвэрлэх" ажлыг өөрсдөө хэрэгжүүлэн ажилчдын ажлын хөлс, шатахууны зардал гаргасан. (Хялганат тосгон)
- Тосгоны хяналтын камер болон дагалдах тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах ажлыг 25.0 сая төгрөгөөр баталсан боловч Тосгоны хяналтын камер болон дагалдах тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах 18.0 сая, Хялганат тосгоны камерын цахилгаан эрчим хүчний агаарын шугам байгуулах 7.0 сая төгрөгийн 2 ажил болгон нэг компанитай шууд гэрээ байгуулсан. (Хялганат тосгон)

2.1.2 Тайланд онд аймаг, сумдын ИТХ-аар 15,472.9 сая төгрөгийн 465 ажил батлагдаж 12202.3 сая төгрөгийн 363 ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулснаас 333 ажил бүрэн хэрэгжиж дууссан ба 30 ажил дутуу хэрэгжиж 1429.4 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Нийт хэрэгжүүлэхээр батлагдсан ажлаас огт хэрэгжээгүй 2,893.7 сая төгрөгийн 101 ажил үлдсэн нь тендер шалгаруулалтыг зохион байгуулах цаг хугацаа, нөөцийг харгалзалгүй олон ажил төлөвлөх, ХАА-г зохион байгуулахдаа улирлын болон онцлог шинж чанартай ажлуудыг хугацаа алдаж тендер сонгон шалгаруулалт зарласан, төсвийг зах зээлийн үнийн дүнгээс бага төлөвлөсөн зэргээс шалтгаалан тайлант онд хэрэгжээгүй зөрчлүүд илэрлээ.

Хүснэгт № 5 ИТХ-аар баталсан хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт
/сая төгрөгөөр/

№	Аймаг, сум	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
		тоо	дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	дүн
1	Аймгийн ОНХС	21	4600.9	19	4417.9	12	2844.9	7	1573.0	2	128.8
2	Сумдын дүн	444	10871.9	344	7784.4	321	516.8	23	2155.4	99	2764.8
	нийт дүн	465	15472.9	363	12202.3	333	8461.7	30	3728.3	101	2893.7

ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулаагүй байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний хөрөнгийг зарцуулахтай холбоотойгоор бусад хууль тогтоомж зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Наадмын талбайн байгууламж /цэнгэлдэх хүрээлэн/ шинээр барих 120.0, Уньт багийн соёлын төвийн их засвар 60.0, Уньт, тээл, Хонгор багт мал тарилгын хашаа барих 33.0 нийт 213.0 мянган төгрөгийн төсөвт өртөгт 3 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан ч ажлыг хэсэг гарган хүлээж аваагүй. (Хутаг-Өндөр сум)
- Тайлант онд 60.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн ч зураг төсөвт тусгагдсан магадалшгүй ажлын зардал болох 1.0, зохиогчийн хяналтын зардал 527.3, захиалагчийн хяналтын зардал 1.0 нийт 2.6 сая төгрөгийг гүйцэтгэгч "Билгүүн мэйрэн" ХХК-д илүү олгосон. (Хутаг-Өндөр сум)
- Тайлант онд өвсний нөөцийг бүрдүүлэхэд тээврийн зардалд 2.0 сая төгрөг, 4.0 сая төгрөгөөр 2000 боодол өвс нийт 10.0 сая төгрөгийг зарцуулж 2000 боодол өвснөөс 65 боодол өвсийг дутуу нийлүүлсэн байна. (Хутаг-Өндөр сум)
- Сайхан, Хутаг-Өндөр, Дашинчилэн сум, Хялганат тосгоны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 7 төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй зөрчилд нийт 16.1 сая төгрөгийн алданги тооцоогүй.
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7.6 дахь заалтыг зөрчин дэмжлэг, тусламж олгосон байна.
- Ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 17.5 сая төгрөгийг зарцуулснаас иргэдэд сонгино болон төмсний үр, 3 иргэнд 3.4 сая төгрөгийн хүлэмж, 1.0 сая төгрөгийн мотор өгсөн байна. (Сэлэнгэ сум)
- ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймгийн тэтгэлэгт хамрагдсан хүүхдэд 1,993.9 мянган төгрөг, 2024 онд 330.0 мянган төгрөг нийт 2,293.9 мянган төгрөгийг олгосон. (Сэлэнгэ сум)

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үе шатанд зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.

2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд бүрэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс 314 нь төлөвлөсөн зорилтод түвшинд хүрч, дараах 4 төсөл хөтөлбөр нь зорилтод түвшинд хүрээгүй байна.



➤ Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайн ажлыг биетээр үзэхэд 1.5 сая төгрөгийн зөөлөвч резин дутуу хийгдсэн байна. (Орхон сум)

➤ ЕБС-ийн шаардлагатай 14.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжийг Иргэн О.Эрдэнэбаттай 2023 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 11/012 тоот гэрээг байгуулж гүйцэтгэл болох 4.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл нийлүүлээгүй. (Сэлэнгэ сум)

➤ 10.0 сая төгрөгийн төсөв бүхий Зорчигч тээврийн зогсоол барих, 20.0 сая төгрөгийн төсөвтэй Худалдааны саравч 2 төсөл арга хэмжээ бүрэн хийгдэж дуусаагүй.

➤ Ахмадын өргөөний барилгын зураг төсвийн гэрээний хугацаа дууссан боловч, ажлын зураг төсвийн үнэ өндөр байсан тул хүлээж аваагүй, санхүүжилтийг дутуу олгосон байна. (Хялганат тосгон)

Аймгийн 16 сум, нэг тосгоноос Булган, Баяннуур, Бүрэгхангай, Могод, Орхон сум ОНХС-гийн хөрөнгөөр 2023 онд төлөвлөн хэрэгжүүлэх ажлуудыг эрэмбэлж, нэгдсэн жагсаалт боловсруулах ажлын хэсгийг томилоогүй, захирамж гаргаагүй нь Сангийн сайдын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Сумдын түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх үе шатны ажлын хэсэг байгуулагдаагүй, баг хороодоос ирсэн саналыг эрэмбэлж нэгтгэхдээ журмын 6.4 дэх заалтын үзүүлэлтүүд, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт, хүрэх дүн болон бусад тооцооллыг хийсэн баримт материал бүрдүүлээгүй. Тухайлбал:

- Тайлант онд 30 төсөл, арга хэмжээний 193.5 сая төгрөгийн ТАХ- иргэдийн саналгүй баталсан байна. (Сэлэнгэ сум)
- Тайлант онд 420.4 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлахдаа хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй зөрчил байна. (Сэлэнгэ сум)

- Тайлант онд ОНХС-ийн баталсан 801.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ-ээс иргэдийн саналгүй 52.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг баталсан байна. (Хутаг-Өндөр сум)
- Тайлант онд 120.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлахдаа хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн Засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй зөрчил илэрлээ. (Хутаг-Өндөр сум)
- Төвийн гудамжны гоёлын гэрэлтүүлгийн ажлыг ТЭЗҮ, төсөвгүй ИТХ-аар баталсан. (Булган сум)
- ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх үе шатны ажлын хэсэг байгуулагдаагүй, баг хороодоос ирсэн саналыг эрэмбэлж нэгтгэхдээ журмын 6.4 дэхь заалтын үзүүлэлтүүд, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргасан эсэх баримт материал бүрдүүлээгүй байна. (Булган сум, Хялганат тосгон)
- Тайлант онд хэрэгжүүлсэн 6 ТАХ-г иргэдийн саналгүй баталсан байна. (Орхон сум)
- Цахимаар авсан иргэдийн саналыг журмын хавсралт 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэж баталгаажуулаагүй. (Хялганат тосгон)

Аймаг, сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁴⁰, 14 дүгээр зүйлийн 14.2.3⁴¹, 14.3⁴², өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Сангийн сайдын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.3.4⁴³ дахь заалтын дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин үр дүнг бодитой тодорхойлоогүй, хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан төслийн төсөвт өртгийн харьцааг тооцсон тоо мэдээлэл байхгүй, тодорхойлсон гэх боловч холбогдох хангалттай зохистой нотлох баримт байхгүй зөрчил илэрлээ.

Иймд өмнөх аудитаар өгсөн “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор төлөвлөж, хэрэгжилтийг тооцож, жилийн гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан дүгнэж ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Малын тоо толгойн албан татварын зарцуулалт

Тайлант онд МТТАТ-аар 2,032.5 сая төгрөгөөр 127 ажил хийхээр төлөвлөж сумдын ИТХ-аар баталснаас 1,287.4 сая төгрөгийн 92 ажил хийгдсэн нь нийт ажлын 72.4 хувь нь хэрэгжсэн байна.

ОНХС-ийн дансанд гүйцэтгэлээр МТТАТ 1,320.5 сая төгрөг төвлөрүүлсэн боловч малчдад чиглэсэн ажилд 1,173.8 сая төгрөг зарцуулсан нь 146.9 сая төгрөг дутуу зарцуулсан байна.

Сумын түвшинд үзэхэд татвар төвлөрүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлснээс шалтгаалж татварын төлөвлөгөө тасардаг мөн ОНХС-ийн дансанд төвлөрүүлсэн татварын санхүүжилтийг бүрэн зарцуулахгүй байгаа нь татвар төлсөн малчид төрийн үйлчилгээг авч чадахгүйд хүрч байна.

Дүрслэл №2 Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ангилал



2.2.2 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн 10,942.8 сая төгрөгийн 363 ажил байгаагаас 992.9 сая төгрөгийн барилга, байгууламж, 1,283.7 сая төгрөгийн явган хүний зам, автозамын засвар, 1,541.6 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн талбай, хүүхдийн тоглоомын талбайн тохижилт, 365.6 сая төгрөгийн

гэрэлтүүлэг, 239.5 сая төгрөгийн худаг, 902.3 сая төгрөгийн дэд бүтэц шугамын ажил, 2,068.7 сая төгрөгийн их засвар ажил зэрэг ажил хийгдсэн нь сум, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.



2.3.1 Бүрэн хэрэгжсэн 307 төсөл арга хэмжээнээс зориулалтын дагуу ашиглаж байгаа 304 төсөл арга хэмжээ буюу 99 хувийг зориулалтын дагуу ашиглаж 3 төсөл арга хэмжээг огт ашиглаагүй байна.



1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр сумын 24 өрхийн хашаа шинэчлэх "Гудамж төсөл" хэрэгжүүлэхээр төлөвлөж 10.0 сая төгрөгийн банз, материал худалдан авсан боловч хашаа шинэчлэх ажил хийгдээгүй төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна. (Орхон сум)
2. Хоёрдогч түүхий эд цуглуулах хашаа, преслэгч авах ажлын хүрээн 16.0 сая төгрөгийн хог преслэгч авсан боловч одоогийн байдлаар нэг ч удаа ашиглаагүй байна.
3. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын ажлын төмөр хийцтэй хашааг худалдан авсан боловч хашааг барьж дуусаагүй байна. (Дашинчилэн сум)

2.3.2 ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн ажлуудыг бүртгэлд тусгаагүй дараах зөрчил илэрсэн. Тухайлбал

- Рашаант сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 244.7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүйг санхүүгийн тайлангийн аудитаар бүртгэлд тусгах зөвлөмж өгсөн байна.

- Хутаг-өндөр сумын ОНХС-ийн баталсан 801.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ-ээс 46.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-г бүртгэл тайланд тусгаагүй байна.
- Сайхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө, зарим хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөхгүй зардлыг ОНХС-ийн тайланд хөрөнгөөр бүртгээнийг аудитын хугацаанд залруулсан.

БҮЛЭГ 3

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчил давтагдан гарсаар байна.

3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих аймаг, сумдын ИТХ-ын хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

3.1.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

Аймгийн болон сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд Баян-Агт, Бугат, Дашинчилэн, Рашаант, Тэшиг сумдын ИТХ-аас хяналтыг хэрэгжүүлсэн, бусад сумдын ИТХ хяналтын ажлыг хийгээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/

Харин хяналт хэрэгжүүлсэн сумдын ИТХ-ын дэргэдэх хороод болон хяналтын бүлэг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг иргэдийн санал авч, эрэмбэлсэн эсэх, багийн ИНХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх, зураг, төсөв, тооцоо, судалгаа нь урьдчилан хийгдсэн, худалдан авах ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудлыг хяналтад хамруулалгүйгээр зөвхөн хэрэгжилт, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан эсэхийг хамруулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг Бугат, Рашаант сум нь хэрэгжүүлсэн, бусад сумдууд огт хэрэгжүүлээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/

Тайлант онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хяналт огт хийгдээгүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй, 2024 онд хийхээр төлөвлөснийг Төрийн аудитын байгууллага аудитыг эхлүүлсэн учир СХДАА нь төлөвлөгөөнд тусгагдсан ОНХС-д хийх хяналт шалгалтыг давхардуулахгүй гэсэн үүднээс цуцалсан байна.

3.1.2 Булган аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 16 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн, 5 төсөл, арга хэмжээнд хэрэгжүүлээгүй байна. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт 6,224.4 сая төгрөгийн 330 төсөл, арга хэмжээний 5,524.5 сая төгрөгийн 295 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж 852.6 сая төгрөгийн 40 төсөл, арга

хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/*

3.1.3 Булган аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэн, аймаг, сумдын дүнгээр нийт 10 төлбөрийн акт 40.0 сая төгрөгөөс 8 төлбөрийн акт 20.4 сая төгрөгийг барагдуулж биелэлт 75.3 хувьтай, 58 албан шаардлага 4,624.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 7-аас харах/*

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг 5 сум журмын дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь заалтуудын дагуу ОНХС-ийн 2023 оны хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т Баян-Агт, Баяннуур, Булган, Хангал, Сайхан зэрэг 5 сум хүргүүлээгүй байна.

Аймаг, сумын ЗДТГ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүйгээс 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.2 Аймаг, сумын ЗДТГ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон дараах 2,556.5 сая төгрөгийн 175 хөрөнгийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 12-аас харах/*

3.2.3 Аудитын явцад Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах аймгийн ОНХС 985.9 сая төгрөгийн 3 мэдээлэл дутуу, 113.6 сая төгрөгийн 1 мэдээлэл оруулаагүй, 7 сум нь 1,237.4 сая төгрөгийн 24 мэдээлэл дутуу, 11 сум нь 1,345.0 сая төгрөгийн 88 мэдээллийг нээлттэй ил тод мэдээлээгүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 11-аас харах/*

Сангийн яам нь удирдлага мэдээллийн системийн “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” цэсээр аймаг, сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнг үнэлж дүгнээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3 дахь

заалтуудыг зөрчин аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх явцын мэдээллийг удирдлага мэдээллийн системд оруулаагүй байхад тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг гүйцэтгэсэн алдаа зөрчил давтагдсаар байна.

3.2.4 Аймгийн ОНХС болон 16 сум, 1 тосгоны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж шалгасан байна. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад Хутаг-Өндөр, Хялганат Хангал, Бугат, Булган, Рашаант зэрэг сумдад зөрчлийг арилгах албан шаардлага өгч, Дашинчилэн, Тэшиг, Могод сумдад зөвлөмж хүргүүлэн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрлэсэн байна. (Хавсралт-2)

Өмнөх аудитаар аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарт ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад 3,593.3 сая төгрөгийг илүү төлөвлөсөн сайн тал байгаач малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төлөвлөж, төвлөрүүлээгүй, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тодорхойлоогүй байна.
- Сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ ажлын хэсэг томилдоггүй, хууль, журмыг баримталдаггүй, баримт материал бүрдүүлдэггүй. ОНХС-гийн дансанд төвлөрүүлсэн малын хөлийн татварын бүрэн зарцуулдаггүй, ИТХ-аар батлагдсан ажлуудыг дутуу хэрэгжүүлж байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг 5 сум журмын дагуу тайлагнаж хүргүүлээгүй, төсөл, арга хэмжээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, удирдлага мэдээллийн системд аймгийн ОНХС 985.9 сая төгрөгийн 3 мэдээлэл дутуу, 113.6 сая төгрөгийн 1 мэдээлэл оруулаагүй, 7 сум нь 1,237.4 сая төгрөгийн 24 мэдээлэл дутуу, 11 сум нь 1,345.0 сая төгрөгийн 88 мэдээллийг нээлттэй ил тод мэдээлээгүй байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон дараах 2,556.5 сая төгрөгийн 175 хөрөнгийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Эрдэнэбат танаа:

1. ОНХС-ийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг төлөвлөн ИТХ-аар батлуулахдаа урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тодорхойлж байх.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд ИТХ-ын зүгээс хяналт хийж, дүнг хэлэлцэж, шийдвэрлэж байх.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Г.Давааням танаа:

1. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлох.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлүүлэх, хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргуулж нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж байх

Сумдын Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээс бүрэн бүрдүүлэхээр төлөвлөх, хандив, тусламжийн болон Малийн тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-ийн дансанд бүрэн төвлөрүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах
2. ОНХС-ийн үйл ажиллагааг хууль, журамд заасны дагуу төлөвлөх, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байх
3. Малын хөлийн татвараар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
4. Удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээллийг оруулах, хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх

Санал:

1. ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах зориулалтыг өөрчлөх сум, байгууллагын хэрэгцээнд төдийхнөөр биш хөрөнгө оруулалтын чанартай арга хэмжээнд зарцуулах болгохоор хууль, журамд өөрчлөлт оруулах